

## ЕВРОП ДАХЬ МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ХОЛБОО “Тогтвортой аялал жуулчлал - Эмэгтэйчүүд” БИЗНЕС ФОРУМЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 5-р сарын 27-ны өдөр  
Турк Улсын Истанбул хот

Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбоо нь 2012 онд Лондон хотноо байгуулагдсан цагаас хойш Европын холбооны улсууд болон бусад улс орнуудад ажиллаж, амьдарч буй бизнес эрхлэгч монгол эмэгтэйчүүдийг дэмжин өөр хоорондоо бизнесийн нэвтрэгч үүсгэх, бизнесийн туршлагаасаа солилцох, хамтран ажиллах боломж бололцоог бүрдүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг Оны шилдэг эмэгтэй шалгаруулах үйл ажиллагааны үеэр бизнес форумыг зохион байгуулж эмэгтэйчүүдийн үүрэг ролийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж ирсэн.


Бизнес форумыг анх 2015 онд Бельгийн Вант Улсын Антверпэн хотноо “Европ дахь Ази эмэгтэйчүүд”, 2016 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд”, 2017 онд Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо “Ногоон бизнес дэх эмэгтэйчүүд”, 2018 онд Бүгд Найрамдах Польш Улсын Варшав хотноо “Эрүүл мэндийн салбар дахь эмэгтэйчүүд”, 2019 онд Шведийн Хаант Улсын Стокхолм хотноо “Боловсрол, шинжлэх ухаан, инновац дахь эмэгтэйчүүд”, 2020 онд “Ковид 19-Бидний амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ” сэдвээр онлайнаар, 2022 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Лондон хотноо “Тогтвортой хөгжил ба эмэгтэйчүүдийн оролцооны ач холбогдол” сэдвээр тус тус зохион байгуулж тухайн салбарын нэр хүндтэй илтгэгч нарыг урьж оролцуулан санал бодол, туршлагаа солилцож байв.

Энэ удаагийн бизнес форумыг Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024, 2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалын салбарыг цар тахлын дараа эргэн сэргээх, хөгжүүлэх, уг салбарт гарч буй шинэ чиг хандлага, бодлого, сорилт бэрхшээл, даван туулах арга зам, боломж, туршлага тэдгээрт эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмэр зэрэг сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой. Түүнчлэн “Монголд зочлох жил”-ийн хүрээнд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмрийг тодотгох, Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжилд оруулж буй Турк улс болон бусад улс орнуудын туршлагаас харилцан солилцох болно.

Бизнес форумд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Турк Улсын Соёл, аялал жуулчлалын яам, Монгол Улсаас Турк Улсад суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас Турк Улсын Истанбул хотод суугаа Ерөнхий консулын газар, Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд, бусад улс орнуудын аялал жуулчлалын салбарт ажиллаж буй нэр хүндтэй байгууллагуудын төлөөлөл оролцож туршлагаасаа хуваалцана.

Welcome to  
**MONGOLIA**





## ЕВРОП ДАХЬ МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ХОЛБОО “Тогтвортой аялал жуулчлал - Эмэгтэйчүүд” БИЗНЕС ФОРУМЫН ХӨТӨЛБӨР

2023 оны 5-р сарын 27-ны өдөр  
Турк Улсын Истанбул хот  
TOBB Plaza, Büyükdere Caddesi, Harman Sokak No.10  
34394 Esentepe/Şişli, Istanbul

09:30-10:00 Зочдыг угтах, бүртгэх

10:00-10:10 **Нээлтийн үйл ажиллагаа**

- *Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбооны Хүндэт Ерөнхийлөгч Д.Энхжаргал*
- *Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Г.Мөнхбаяр*

10:10-10:30 **Зочин илтгэл**

- *Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Саянаа*
- *Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөх А.Ариунзаяа*

10.30-11.30 **Хэлэлцүүлэг I. Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих хөшүүрэг, чиг хандлага, туршлага**

*Чиглүүлэгч: Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яамны зөвлөх С.Уянга*

- *Их Британи-Монголын Худалдаа аж, үйлдвэрийн танхимын дарга, Их Британийн парламентын гишүүн асан Жон Гроган /цахимаар/*
- *Турк Улсын Худалдаа, аж үйлдвэр, биржүүдийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Адем Кула*
- *“Easyticket and Travel” ХХК-ийн үүсгэн байгуулагч, ерөнхий менежер Онур Гөкхан Хаквар*
- *Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газрын Инновацын төв, гарааны бизнесийн хэлтсийн дарга, “Даян дэлхийн монгол эмэгтэйчүүд хамтдаа” ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Жаргалмаа*

11.30-11.45 **Цай, кофе завсарлага**


11.45-12.40 **Хэлэлцүүлэг II. Аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ боломж нөхцөл, хамтын ажиллагаа, түншлэл**

- *БНТУ-ын Истанбул хотын Гэбзе эмнэлгийн гастроэнтерологийн их эмч Б.Мөнхцэцэг*
- *Өвөрхангай аймгийн “Өв-Өгөөмөр” сувиллын газрын захирал Ё.Цэцэгээ*
- *ХБНГУ-ын ‘Одха трэйвэл’ компанийн төлөөлөгч Д.Одмаа*
- *“Orso Voyage Sarl” компанийн захирал О.Чимэгмаа*
- *“Ocidisci” хөрөнгө оруулалтын компанийн захирал Хакан Окудужу*

12.40-12.55 **Хэлэлцүүлэг III. Дүгнэлт (уриалга)**

12:55-13:00 **Хаалтын үг**

- *Истанбул дахь Монгол Улсын Ерөнхий консулын газрын Ерөнхий консул Ш.Хишигсүрэн*
- *Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбооны Хүндэт Ерөнхийлөгч Д.Энхжаргал*



## ЕВРОП ДАХЬ МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ХОЛБОО “Тогтвортой аялал жуулчлал - Эмэгтэйчүүд” ТАНИЛЦУУЛГА

2023 оны 5-р сарын 27-ны өдөр  
Турк Улсын Истанбул хот

### ХҮНДЭТ ЕРӨНХИЙЛӨГЧ



#### **Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбооны үүсгэн байгуулагч, Хүндэт ерөнхийлөгч Д.Энхжаргал**

Төв банк, төр засгийн байгууллага, үндэстэн дамнасан санхүүгийн байгууллагад 30 гаруй жил удирдах албан тушаал хашсан. ОХУ-ын их сургуулийг банк, санхүүгийн мэргэжлээр шилдэг үнэлгээтэй төгссөн. АНУ-ын Вандербилтийн их сургуульд эдийн засгийн хөгжлөөр магистрийн зэрэг хамгаалсан. Монголын төв банкны дэд ерөнхийлөгчийн албыг хашсанаар банкны салбарт өндөр албан тушаалд

томилогдсон анхны эмэгтэй болсон. Түүний мэргэжлийн ур чадвар, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж “Шилдэг банкир”, “Хөрөнгө үнэт цаас арилжааны тэргүүний ажилтан”, төр засгийн “Алтан гадас” одон, “Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль” зэргээр шагнаж урамшуулсан. Одоогоор хэд хэдэн төрийн бус байгууллагын удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн байгууллагын гишүүнээр ажилладаг.

### ХҮНДЭТ ЗОЧИН



#### **Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Г.Мөнхбаяр**

Уралийн политехникийн дээд сургуулийг инженер мэргэжлээр төгссөн. Техникийн инженерээс эхлэн хотын ерөнхий менежер, Улаанбаатар хотын Захирагчийн албаны дарга зэрэг албан тушаалуудыг хашиж байсан ба төрийн албанд 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрбээр Улаанбаатар хотын Засаг дарга, Улаанбаатар хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргаар, мөн Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан.



#### **Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Саянаа**

Монгол Улсын Их Сургууль, АНУ-ын Жорж Вашингтоны их сургуулийг тус тус төгссөн. Сургуулиа төгсөөд Жорж Вашингтоны их сургуульд судлаачаар ажиллаж байсан. Ажлын гараагаа Deloitte Consulting-д менежментийн туслах ажилтнаар ажиллаж эхлэн, НҮБ-ын болон НҮБХХ-ийн олон төсөл дээр ажилласан. 2009-2012 онд Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн даргын гадаад бодлогын зөвлөх, 2014-2021 онд Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны дарга, ахлах зөвлөх болон гадаад бодлого, гамшгийн эрсдлийг бууруулах, оюуны өмч, хариуцсан зөвлөхөөр ажилласан. 2021 онд Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн

эрхт Элчин сайдаар болон Бүгд Найрамдах Умард Македони Улс, Бүгд Найрамдах Грек Улс,

Бүгд Найрамдах Кипр Улс, Бүгд Найрамдах Молдова Улс болон Румын Улсад хавсран суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдон ажиллаж байна. Л.Саянаа Junior Chamber International байгууллагад удирдлагын түвшинд олон жил ажилласан бөгөөд уг байгууллагын Зүүн Европын хариуцсан Дэд Ерөнхийлөгч, Ази, Номхон далайн хөгжлийн зөвлөлийн дарга, Өсөлт хөгжлийн хорооны дарга зэрэг сонгуульт албуудыг хашиж байсан.



### **Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөх А.Ариунзаяа**

Төрийн болон хувийн хэвшилд ажиллаж байсан туршлагатай. Даатгалын салбарт хүний нөөцийн менежер, ерөнхий менежерээр 2005-2013 онд ажилласан. Монгол Ардын Намын Удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, Нийгэм, эдийн засгийн бодлогын хөгжлийн газрын даргаар тус тус 2013-2016 онд ажиллаж байсан. Тэрээр 2016-2020 онд Үндэсний статистикийн хорооны даргаар ажилласан. Монгол-Оросын хамтарсан сургуулийг төгссөн бөгөөд Германы Халле дээд сургууль, Ханноверийн их сургуулийг улс төрийн шинжлэх ухаан, социологи, түүхийн ухааны магистрийн зэргээр төгссөн. Дараа нь ЭЗИС-ийг бизнесийн удирдлагаар, мөн АНУ-ын Жоржтуаны их сургуулийн Олон улсын хуулийн сургуулийг олон улсын манлайлал, удирдлагын чиглэлээр төгссөн. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар 2020-2022 онд ажилласан. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхөөр ажиллаж байсан.

### **ИЛТГЭГЧИД**



### **Британи-Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга Жон Гроган**

Их Британийн улс төрч, 1997-2010 онд Их Британийн парламентын гишүүнээр ажилласан байсан. Одоо Их Британи-Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын даргаар ажилладаг. Лийдс болон Оксфордын их сургуулийг төгссөн бөгөөд Лийдс хотын зөвлөлд харилцаа холбооны зохицуулагчаар 1987-1994 онд, дараа нь 1996-1997 онд өөрийн бизнесийг эрхэлсэн. Лийдс болон Уолверамптонд Хөдөлмөрийн намд олон ажил алба хашсан. 1995 онд Брюсельд Европын парламентэд Хөдөлмөрийн намын хэвлэлийн төлөөлөгчөөр ажиллаж байсан. Парламентын гишүүнээр ажиллахдаа 1997-2001, 2005-2010 онд Хойд Ирландын хорооны гишүүнээр, мөн парламент дахь BBC, Шар айраг, Монголын бүлгийн даргаар тус тус ажиллаж байсан. Түүний Селбигийн тойрогт өөрчлөлт орсноор 2006 оны сонгуульд нэр дэвшээгүй. Харин 2015 онд Кэйлигээс Хөдөлмөрийн намын нэр дэвшигчээр сонгогдсон. Йоркийн Хөдөлмөрийн клубын хүндэт ерөнхийлөгч, Фабиан нийгэмлэг болон Олон нийтийн бодлогын судалгааны хүрээлэнгийн гишүүний сонгуультай. Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбооны хүндэт патрон.



### **Турк Улсын Easyticket and travel компанийг үүсгэн байгуулагч, ерөнхий менежер Онур Гөкхан Хаквар**

1999 онд Пуан тур компаниас аяллын зөвлөхөөр ажлын гараагаа эхэлсэн ба сүүлд 2007 он хүртэл корпорацийн газрын менежерээр ажилласан. Түүнчлэн Ази тур компанид аяллын зөвлөхөөр 2001-2003 онд ажилласан. Харин 2007 онд өөрийн аялал жуулчлалын компанийг Easy ticket and travel нэртэйгээр байгуулсан. Энэхүү компани нь олон улсын болон орон нутгийн нислэгүүдийн тасалбарыг боломжит үнээр аялагчдад олгоход дэмжлэг үзүүлдэг. Тус компани 2014 оноос эхлэн Монголын аялал жуулчлалын салбарт ажиллаж байна. Онур Монголчуудын шинэ жилийн үдэшлэгт нислэгийн үнэ төлбөргүй тасалбарыг олгож дэмжлэг үзүүлж ирсэн түүний ажил бараг уламжлал болжээ. Түүнчлэн нислэгийн тасалбарыг үнэ төлбөргүй олгохоос гадна Монголчуудын дунд зохиогдсон спортын тэмцээн уралдаан болон Европын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах монголчуудын тэмцээнийг байнга ивээн тэтгэж оролцож ирсэн. Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбооны дэмжигч, хүндэт патроноор ажилладаг.



### **Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газрын Инновацын төв, гарааны бизнесийн хэлтсийн дарга, “Даян дэлхийн монгол эмэгтэйчүүд хамтдаа” ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Жаргалмаа**

Инновац, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологи, олон улсын харилцааны мэргэжилтэн. 2018 оноос хойш Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газрын Инновацын төв, гарааны бизнесийн хэлтсийн даргаар ажиллаж байна.

Одоогийн ажлынхаа хүрээнд инновац, стартапуудтай холбоотой бодлого, журмыг боловсруулах чиг үүрэгтэй Улаанбаатар хотын инновацын төвийг ажиллуулж, төслүүдийг хөгжүүлэх, инновац болон үйлдвэрлэлийн экосистемийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд Хөгжлийн бодлогын газрын төсөл хамтын ажиллагааны менежер, Монгол Ардын Намын Гадаад харилцааны улс төрийн ажилтан, Шинжлэх ухаан соёлын төвд реферэнтээр тус тус ажиллаж байсан. Монгол Улсын Техникийн Их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, ОХУ-ын Кубаны их сургуулийг улс төрийн шинжлэх ухааны бакалаврын зэргээр төгссөн. Бодлогын хөгжил, харилцаа холбоо, смарт засаглал, жендэрийн мэдрэмжтэй байдал, мэдлэг ойлголт олгох чиглэлээрх хэд хэдэн хөтөлбөр сургалтад хамрагдсан.



### **Турк Улсын Истанбул хотын Гэбзе эмнэлгийн гастроэнтерологич, зөвлөх эмч**

Гэбзе эмнэлэгт эмч, зөвлөх эмчээр ажилладаг. Истанбулын их сургуулийг, мөн Мармарагийн их сургуулийг дүүргэсэн. Молекуль биологийн илтгэлүүд, Гастроэнтерологийн Америкийн сэтгүүл, Дотоод эмийн Европын сэтгүүл зэрэг нэр хүндтэй хэвлэлүүдэд өөрийн судалгааны бүтээлүүдийг хэвлүүлсэн. Үйлчлүүлэгчийг эмчтэй гар утсаар холбож өгөх “Эмч апп”-ийг бүтээсэн ба өөрийн эх хэл дээр эрүүл мэндийн

үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлдэг. Энэхүү санаачлага нь оршин суух зөвшөөрөл, газар нутгийн байршил, эрүүл мэндийн өндөр үйлчилгээнэс хамааран хэрэгцээт эрүүл мэндийн үйлчилгээг авч чадахгүй байгаа цагаач иргэд, монголчуудад үнэхээр үнэ цэнтэй болсон. Өнөөдөр “Эмч апп” нь нарийн мэргэжлийн 450 эмчтэй ба 200 мянган хэрэглэгчтэй эрүүл мэндийн дижитал орчинд эхний ээлжинд орох үйлчилгээг үзүүлж байна. Мөнхцэцэг нь Туркийн гастроэнтерологийн холбооны гишүүн эмч бөгөөд Монголын эрүүл мэндийн аялал жуулчлалын төлөөлөгчөөр ажиллаж байна.



### **Өвөрхангай аймгийн Тарагт сумын “Өв-Өгөөмөр” сувиллын дарга Ё.Цэцэгээ**

Монгол Улсын Их Сургуулийг харилцаа холбооны инженер мэргэжлээр төгссөн. Тэрээр 1988 оноос хойш эмэгтэйчүүдийн байгууллагад идэвхтэн сонгуульт алба хашсан. 2005 онд Өвөрхангай аймгийн Тарагт суманд эрүүл мэндийн сувиллын газраа нээсэн бөгөөд эрүүл мэндийн аялал жуулчлал эрхэлдэг “Өв-Өгөөмөр” компанийг байгуулан ажиллаж байна. Орон нутгийн эмэгтэйчүүдийн хөгжил, малчин өрхийн эх үрсийг хамгаалах, эмэгтэйчүүдийн төрөхийн өмнөх болон дараах асаргаа сувилгаа, өрх толгойлсон эхчүүдэд дэмжлэг үзүүлэх зэргээр эмэгтэйчүүдийн байгууллагад 35 жил гаруй ажиллаж буй туршлагатай. Тэрбээр үндэсний болон олон улсын хэмжээний байгууллагатай хамтран олон төсөл хэрэгжүүлж хэд хэдэнд улсад боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад хамрагдаж байсан.

### **ХБНГУ-ын ‘Odkha Travel’ компанийн төлөөлөгч Д.Одмаа**

Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуулийг ургамал судлаач, агрономист мэргэжлээр төгссөн. 2001-2003 онд Хөдөө аж ахуйн сургууль, Германы Weinstephan их сургуулийн хамтарсан төсөлд профессорын туслахаар ажилласан. 2006 оноос аялал жуулчлалын салбарт орчуулагч, тайлбарлагчаар ажиллаж эхлэн өнөөг хүртэл ажиллаж байна. Нөхөр болох Франк Рийдэнгийн хамт 2012 онд ‘Odkha Travel’ компанийг байгуулан Герман болон Европын зах зээлд Монголыг танилцуулах ажлыг хийж байна. Одмаа нь “The image of Mongolia” хэмээх номын хамтран зохиогчоор ажилласан. Энэхүү ном нь ITB 2015 үзэсгэлэнгээс шилдэг номоор шалгарч байсан. Мөн гэр бүлийн компани нь “Long Road Back to Home”



баримтат киног хийж гаргасан. Мөн нөхрийн хамт 'People to People' хэмээх слайд шоуг 10 гаруй жил хийж байна. Түүний нөхөр эмзэг бүлгийн монгол хүүхдүүдийг Германд эмчлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 'Mongolia Help' ТББ-ыг үүсгэн байгуулсан. Энэхүү байгууллагын үйл ажиллагааг гэр бүлээрээ дэмжиж хамтдаа Монголын хүүхдүүдийн эрүүл мэндийн төлөө дэмжиж ажиллаж байна.



**“Orso Voyage Sarl” компанийн захирал О.Чимэгмаа**

1994-1998 онд Гадаад хэлний их сургуулийг, 1998-2002 Францын Тулуйзийн их сургуулийн орчуулагчдын хүрээлэнд суралцсан. Мөн Тулуйз хотын Улс төр судлалын хүрээлэнд цэргийн социологи болон олон улсын харилцааны асуудлаар магистрийн зэрэг, мөн улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр докторын зэргийг 2008 онд хамгаалсан.

2005 онд Orso Voyage Sarl компанийг байгуулан аялал жуучлалын салбарт ажиллаж буй бөгөөд аялал жучлалын багцыг Франц хүмүүст санал болгох, Монгол руу аялал зохион байгуулах чиглэлээр ажилладаг байна.



**Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод суугаа Ерөнхий консул Ш.Хишигсүрэн**

Анкарагийн Их Сургуулийн Хууль зүйн факультетыг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Мөн сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны институтэд иргэний эрх зүйн магистрийн зэрэг хамгаалсан.

Хууль зүйн үндэсний төвд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаад 2009 онд Улсын Их Хурлын Тамгын газарт референт, зөвлөх болон ахлах зөвлөхөөр 10 гаруй жил ажилласан. 2020 оны 3 дугаар сараас Истанбул хотод Ерөнхий консулаар ажиллаж байна.


**ЧИГЛҮҮЛЭГЧ:**



**Монгол Улсаад Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яам, ЮНЕСКО-ийн дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газрын зөвлөх С.Уянга**

Турк Улсын Измир хотын Бужа боловсролын факультетэд суралцаж төгссөн бөгөөд Монгол Улсын Удирдлагын Академийн төрийн захиргаа, удирдлагын сургуулийг дүүргэсэн. Их Британийн Лофборо их сургуулийн Олон улсын засаглал, дипломатын академийг дипломат харилцаа, төрийн байгуулал, гадаад бодлогын чиглэлээр магистрийн зэрэг хамгаалсан. Ажлын гараагаа улс төрийн намын залуучуудын байгууллагаас

эхлэн сонгуулийн хэд хэдэн кампанит ажил, нийгмийн төслүүдэд оролцож байсан. 2012 онд Их Британи Улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яаманд ажилласан. Дараагаар нь 2016 оноос ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж боловсрол, соёл, шинжлэх ухаан, харилцаа холбооны олон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан ажиллаж байсан. 2021 оны 8 сараас Монгол Улсаас БНФУ-д суугаа Элчин сайдын яам, ЮНЕСКО-ийн дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт зөвлөхөөр ажиллаж байна. “Тэгш эрх, манлайлал” ТББ, “Аарч” зөвлөх компанийг үүсгэн байгуулагч, Европ дахь Монгол Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүний сонгуультай.



**ASSOCIATION FOR THE DEVELOPMENT OF MONGOLIAN WOMEN IN EUROPE**  
**“WOMEN IN SUSTAINABLE TOURISM”**  
**BUSINESS FORUM REGISTRATION**

**Saturday, 27 May 2023**

TOBB Plaza, Büyükdere Caddesi, Harman Sokak No.10  
 34394 Esentepe/Şişli, Istanbul

No	Surname	Name	Position/Organization
1	Danzanbaljir	Enkhjargal	Honorary President of the Association for the Development of Mongolian Women in Europe
2	Gombosuren	Munkhbayar	Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia to the Republic of Türkiye
3	Lkhagvasuren	Sayanaa	Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia to the Republic of Bulgaria
4	Ayush	Ariunzaya	Adviser to the Minister of Environment and Tourism of Mongolia
5	Sukhbaatar	Uyanga	Counsellor, Embassy of Mongolia to the Republic of France
6	Grogan	Jonh	Chairman, of the British Mongolian Chamber of Commerce
7	Gokhan Hakvar	Onur	Founder and General Manager of Easy ticket and Travel
8	Ganzorig	Jargalmaa	Head of Innovation Centre and Entrepreneurship Department at the Business and Innovation Development Agency of Ulaanbaatar City
9	Adem	Kula	Secretary General, TOBB
10	Banzragch	Munkhtsetseg	Doctor at Gebze Hospitalm Istanbul, Turkiye
11	Yondonpurev	Tsetsegee	Director of Uv-Uguumur health resort, Uvurkhangai province, Mongolia
12	Duuvai	Odmaa	Tour guide interpreterm Odkha travel, Germany
13	Orosoo	Chimegmaa	Director of Orso Voyage Sarl, France
14	Sharav	Khishigsuren	Consular General, Consulate General of Mongolia in Istanbul
15			Turkiye Culture and Tourism Ministry
16	Tuvdenbaatar	Gerelmaa-Lunter	Mongolian-Netherlands interpreter
17	Riedinger	Frank	Computer graphics & Photographers
18	Dashkhuu	Ulziimaa	Geographer, Germany
19	Sakhiya	Odonchimeg	Doctor, Poland
20	Chimeddorj	Bolormaa	Sales manager, Austria
21	Saraisandamba	Sanchir	Director of Polytechnic college of Uvurkhangai province
22	Renchinpeljee	Narantuya	Specialist of the provincial education department
23	Tumennasan	Bayansan	Executive manager “Tumis tour”. Germany
24	Conacher	Erdenchimeg	Lecturer at College, UK
25	Moriton	Una	Anir Anun Beauty Clinic,UK
26	Uvgunkhuu	Zandan	Engineer, UK
27	Clark	Janet Laura	Lecturer at College, UK
28	Dendev Eveson	Undarmaa	Retired doctor, UK
29	Erkhembayar	Nergui	Director of “Ireedui” school of Antwerp in Belgium
30	Banzragch	Oyunchimeg	Dance teacher of “Ireedui” Mongolian school Antwerp in Belgium
31	Sosorbaram	Oyuntungalag	Marketing manager of “Ireedui” Mongolian school Antwerp in Belgium
32	Danzandorj	Dolgortsend	“Ireedui” Mongolian school Antwerp in Belgium
33	Nergui	Bolorzul	Leader of dance group “Bansemeruu” of “Ireedui” Mongolian school Antwerp in Belgium
34	Gansukh	Sainzaya	Film actrice and dancer of “Bansemeruu” dance group of “Ireedui” Mongolian school Antwerp in Belgium
35	Bayaraa	Batbayar	TV director “TV correspondent of the Mongolian national TV” in Belgium

36	Baljina	Saran	Director of MGL Sushi company, France
37	Puntsagdelger	Bolormaa	Director of Bolor Cargo company, Swiss
38	Khorloo	Otgontsetseg	Manicure and Pedicure, Suvd Nails salon, Swiss
39	Doniddagva	Suvd-Erdene	Massage therapy, Pearl Massage Therapy, Swiss
40	Amgalan	Narantuya	Massage, acupuncture, France
41	Zorigt	Badamtsetseg	Self-employed, Swiss
42	Lkhagvajav	Otgonzul	Health Training academic medicine student Swiss
43	Purecsuren	Ganjidmaa	Accountant, Swiss
44	Davaasuren	Darisuren	Secretary of Swiss and Mongolian association
45	Manlai	Munkhbayar	Chocolate Factory, France
46	Batbold	Selenge	Yoga instructor, therapist, Swiss
47	Baatar	Atartsetseg	Mongolian teacher, Hana Group, France
48	Rentsendorj	Narangerel	Bar owner, Swiss
49	Baiviikhuu	Sarantsetseg	Therapist at Beauty salon, Swiss
50	Batsukh	Sarangerel	Ireland
51	Brennan	Tsengel-Erdene	Ireland
52	Batsuuri	Zayajargal	Ireland
53	Gantogtokh	Enkhtuul	ADMWE Representative in Ireland
54	Munkhbat	Narantuya	Ireland
55	Ochirbat	Erdenebayar	Ireland
56	Chuluunkhuu	Ariunmurun	Ireland
57	Rentsen	Battsengel	ADMWE Representative in Poland
58	Jambasuren	Tugsjargal	Supervisory Board Chair, Global Mongolian Women Together NGO
59	Munkhuu	Amarjargal	Private Doctor
60	Jasrai	Narantuya	Head of Bureau of the Recreational Area, Environmental Agency of the City Ulaanbaatar
61	Gotov	Ariuntuya	President, National Association of Eco producers
62	Gantsogt	Erdene-Ochir	Dealer, Monforex
63	Magsar	Semjidmaa	Board Deputy Chair, Social Democracy Women in Darkhan aimag
64	Nadmid	Suvdaa	Board Chair, Social Democracy Women in Darkhan aimag
65	Yadamdorj	Tuyasaikhan	Board Member, Social Democracy Women in Darkhan aimag
66	Tumenduuren	Tsengel	Board Member, Social Democracy Women in Darkhan aimag
67	Kadir Melville	Leila	Türkiye
68	Gombosuren	Bolormaa	ADMWE Representative in Türkiye
69	Agar	Nizamettin	Türkiye
70	Karadeniz	Aysun	Türkiye
71	Fasal	Serap	Türkiye
72	Sukhbaatar	Saruul	Türkiye
73	Lkhagvasuren	Byambasuren	Türkiye
74	Myagmarsuren	Dorj	Türkiye
75	Yamarin	Munkhtuya	Türkiye
76	Batsukh	Oyunchimeg	Türkiye
77	Khishgee	Delgersuren	Türkiye, private guide
78		Gerelmaa	Stockholm
79	Naidanjargal	Tugsjargal	Türkiye
80	Banzragch	Altanzul	Türkiye
81	Zeynep	Maral	Türkiye
82	Sharavdorj	Urtnasan	Türkiye
83	Lkhgva Amuran	Uranimeg	Türkiye
84	Narantsetseg	Munkhtsetseg	Türkiye
85	Gankhuyag	Darkhantsetseg	Türkiye
86	Okuducu	Hakan	Okuducu investment holding company
87	Dangaa	Munkhtsetseg	Türkiye
88	Dangaa	Mungunchimeg	Türkiye
89	Batdorj	Battsetseg	Türkiye



90	Khudersuvd	Munkhzul	Turkiye
91	Shirnen	Odontuya	Turkiye
92	Bold	Dolgor	Turkiye
93	Byaruuzana	Purevsuren	Turkiye
94	Muhammed	Gungor	Turkiye
95	Amarjargal	Munkhuu	Turkiye
96	Erdene-Ochir	Gantsogt	Turkiye
97	Altantsetseg	Jarantai	Singer/Mongolia
98	Batbayar	Bilguun	Turkiye
99	Hulya	Anar	Turkiye
100		Erdenebat	Consulate General of Mongolia in Istanbul
101	Tasdemir	Nihat	Turkiye
102	Tsagaan	Shurentsetseg	Director, Anfisa LLC
103	Sambuudorj	Jambajav	Member of Soroptimist club
104	Zuglegmaa	Uugantsetseg	Director, Munkhkhayazgaargui LLC
105	Sumiya	Ul-Oldokh	Director, Buyannemegdekh LLC
106	Bataa	Enkhmend	Director, Torgo LLC
107	Tsendkhuu	Bolormaa	Director, UB Nara Beauty Salon
108	Tsendkhuu	Baugalmaa	Manager, UB Nara Beauty Salon
109	Enkhbat	Bishrelt	Manager, Khushigt Trade LLC
110	Sandag	Enkhjargal	Czech Republic
111	Buren-Amar	Uugantsetseg	
112	Jargalsaikhan	Zambaga	
113	Dorj	Tungalag	
114	Gataav	Oyunbileg	Ankara
115	Baatar	Munkhzul	Ankara
116	Chimeddamba	Lkhagvadulam	Manager, Khadag tour LLC
117	Nyambayar	Uugantsetseg	Germany
118	Jitka	Psejova	Business development
119	Jargalsaikhan	Enkhchimeg	Business development
120	Shauet	Gulfairuz	Turkiye